

ШАШНЫ БОЛОВСРОЛЫН ТУХАЙД

Д.Энхжаргал

Abstract

On religious education

In this paper the author considered about religious education for public in Mongolia and showed preferences to provide religious education for public. According to the survey, most people have only superficial notion about their religion. They claimed that their religious practices imitate the old people without definite realization beyond the rituals. May be, lacking of righteous knowledge of religion causes modern problems including ignorance of valuable mental heritage and somewhat narrow mind of religion, disrespect others' beliefs and deterioration of kindness and morality. Religious education, when conducted appropriately, will help young people learn to deal sensitively with religion and religious differences and develop the kind of sympathy. Especially, it can help people understand to each other well and establish right ethic and social order.

Түлхүүр үг: Шашин, шашны боловсрол, уламжлалт гүн ухааны сэтгэлгээ, ёс суртахуун.

Удиртгал: Өөрчлөгдөн шинэчлэгдэж буй өнөөгийн дэлхий ертөнцтэй хөл нийлүүлэхийг хичээж буй манай улсын хувьд өдгөө тулгамдаад буй чухал асуудлуудын нэг нь монголын нийгмийн сэтгэлзүйн тогтвортой бус байдал, ёс суртахууны доройтол, оюуны тусгаар тогтнолын хэврэгшилд нөлөөлж буй хүчин зүйлсийг зөв тодорхойлж, түүнийг шийдвэрлэх оновчтой гарцыг олох явдал болж байна. Миний бие, манай нийгмийн дээрх санаа зовоосон асуудалд нөлөөлж буй нэг хүчин зүйл нь монголчуудын уламжлалт сурган хүмүүжүүлэх мэдлэг ухааны хомсдол, түүний дотор шашин шүтлэгээр дамжин төлөвшдөг байсан зан заншил, ёс суртахуун, хүн ёсны эрхэм чанарууд алдагдаж байгаа явдал хэмээн үзэж судалгааны ажлаа үүнд чиглүүлэн ажиллав. Эндээс шашны боловсрол гэж юуг ойлгох, түүнийг үл ойшоох нь дээрх сөрөг нөхцөл байдалд ямар нэгэн хэмжээгээр нөлөөлж буй эсэх, шашны боловсролын хэрэгцээ шаардлага, гүйцэтгэх үүрэг, ач холбогдлыг тусгайлан судлах, түүнийг тодорхой түвшинд хэрэгжүүлэх боломж, арга зам бий эсэхийг тодруулах шаардлага урган гарч байгаа юм. Тиймээс дээрх олон асуудлаас энэ удаа шашны боловсролын тухайд хөндөн үзэхийг зорилоо.

Үндсэн агуулга. Шашны боловсролын тухай ярихаас өмнө "шашин" гэдгийг тодруулах нь зүйн хэрэг юм. Шашин нь нийгэм түүхийн хөгжлийн

явцад хүмүүсийн ертөнцийг үзэх үзлийн салшгүй бүрэлдэхүүн болж, нийгмийн хөгжлийн үе шат бүрт эерэг, сөрөг ямарваа нэг байдлаар идэвхтэй нөлөө үзүүлсээр ирсэн бөлгөө. Тухайн түүхэн цаг үед гүйцэтгэсэн үүрэг, түүний мөн чанараас хамааран, шашныг үзэх үзэл, хандлага нийгмийн хувьсал хөгжлийн үе шат бүрт харилцан адилгүй байжээ.

Шашин гэж юу вэ?. Энэ асуултыг эрдэмтэн судлаачидүгийнгаралүүслээсньэхлэнтайлбарлаж, өөр өөрсдийн үзэл онолоо боловсруулан, олон янзын тодорхойлолтыг өгсөөр иржээ. "Шашин" буюу "religion" хэмээх нэртомьёо нь урт хугацааг туулсан бөгөөд үгийн гарал үүслийн талаарх нэгдмэл үзэл баримтлал өнөөг хүртэл хараахан зүгшрээгүй байна. Өрнөдөд XVI зуунаас өмнө өнөөгийн бидний ойлгож заншсан хэрэглээтэй холбоогүй утга агуулгатай ч байжээ. Тухайлбал, "дахин унших", "хянуур байх" гэсэн үгийн үндсээс үүссэн гэдэг. Мөн "уях, холбох, нэгтгэх" гэсэн утгыг илэрхийлдэг "leig"-ээс үндэслэсэн гэж үзэх явдал нилээд магадлалтайд тооцогддог. Энэ нь Лактантусын "Тэнгэрлэг Институтууд" IV зууны эхэн, Августины "Үнэн шашны тухай" V зууны эхэн, эергээс Вильям Камдений "Британиа" (1586) хүртэл гол ойлголт болж байв¹⁹.

Эртний латин хэлэнд "religio/religiones" гэсэн нэр үгс, religiosus гэсэн тэмдэг нэр болон religiose гэдэг дайвар үг нь ёс жаягийг хянуур гүйцэтгэхтэй холбоотой сүсэг бишрэлийн нэртомьёонууд

¹⁹Jonathan Z. Smith. 1998. "Religion, Religions, Religious." *Critical Terms for Religious Studies*, edited by Mark C. Taylor. Chicago & London: The University of Chicago Press. p 269

байжээ. Энэ нь өдгөө англи хэлэнд “religiously” буюу ухамсартайгаар давтдаг үйлдлийг заадаг дайвар үг болж үлдсэн байна. “She reads the morning newspaper religiously”. Тэр өглөөний сонинг тун нухацтайгаар уншдаг”.¹

Мөн “европ дахинд латин гаралтай “religio” буюу шашин хэмээх үгээр эртний ромчууд тахил шүтээний ёсоо нэрлэж байжээ. НТӨ I зууны үед амьдарч байсан Ромын сэтгэгч, уран илтгэгч Цицерон “Бурхадын утга учир” зохиолдоо ромчууд тахил шүтээний ёсоо “шашин” хэмээн нэрлэж байсныг дурдсан нь буй. НТ I зууны үед христосын ёсон үүсэхдээ ромчуудын энэ үгийг бусад сүсэглэлээс ялган хэрэглэх болсон гэдэг²⁰.

Харин НТ IV зууны үед христосын сүм хийдийн эцэг хэмээн түүхнээ тэмдэглэгдсэн Августин хүнийг ертөнцийн эзэнтэй холбох сургаалийн цогцыг шашин хэмээх бөгөөд энэ утгаараа христос бол шашин мөн хэмээн томъёолжээ²¹. Харин V зууны үеэс уг томъёолол Христийн шашинд өргөн хэрэглэгдэх болсон бөгөөд “religion”- сүм хийдийн сахил санваараар нөхцөлдсөн амьдрал, “religious”- ламтан, “to enter religion”- сүм хийдэд нэгдэх гэсэн ойлголт болсон байна²².

Ийнхүү шүтэн бишрэхүйн ёс, утгаар “шашин” хэмээх үг европ дахинаа дэлгэрчээ.

Харин дорно дахинд, түүний дотор монгол хэлэнд шашин гэдэг нь “шасна”- заан засагч хэмээх утгатай санскрит гаралтай үг. Утга нь нисванис ба тийн атгагаас засаад муу заяа ба сансраас аврахын тул тийн хэмээн өгүүлсэн гэдэг. Энэ утгыг тайлан хожмын мэргэд “Ертөнцийн тусыг бүтээгч сургаал” хэмээн тайлбарласан нь буй²³. Судлаачдын үзсэнээр, монголоор “шашин” хэмээх нь шасна гэдэг үгээс шууд гаралтай хэвшсэн хэллэг бөгөөд өдгөө европ дахины “религио” хэмээхтэй дүйлгэн хэрэглэх болсон байна.

Эндээс “шашин” гэдэг ойлголтын ерөнхий утга нь хүн байгальтайгаа, хүн, хүнтэйгээ харьцах харилцааны явцад бий болгосон үзлийн систем болох нь харагдана. Шашин гэдэгт эрдэмтэн судлаачдын өгч буй голлох тодорхойлолтуудыг нэгтгэн үзвэл, ариун гэгээн зүйлд хандсан шүтлэг бишрэл, зан үйлийн цогц систем гэсэн утга түгээмэл агуулагддаг.

“Шашин бол ард түмнийг мунхруулагч хар тамхи мөн” гэх К.Марксын хэлсэн үг бидний шашинд хандах хандлага, үнэлэмжийг бараг бүтэн зууны туршид тодорхойлж байсан гэхэд хилсдэхгүй юм. Тиймээс шашин, шашны боловсрол хэмээх ойлголтыг зөвхөн Гандан хийд, лам хуврагт хамааруулан, иргэний боловсролтой сөргөлдүүлэн тавьж, үзэж ирсэн нь өнгөрсөн социалист нийгмийн онол, үзэл суртлын бодлогын үндсэн хандлага байв. Түүгээр ч үл барам өнөөдөр ч төр, шашин ангид

тусдаа байх хуулийн заалт хийгээд өөрийн шашныхаа мөн чанарыг гүн гүнзгий ухаардаггүй, мухар сүсэг төдийхнөөр асуудалд хандаж, хөндий хуумгай ойлгодог явдал бидний байсаар байгаа бөгөөд энэ нь нэг талаар, бид бүхний хуучирсан суртал хэвшилтэй холбоотой юм.

Үүнийг тэрлэгч судлаач миний өгүүлэн буй шашны боловсрол гэдэгт сүм хийд, лам хуврагуудын үйл ажиллагааны тухайд бус, харин хүмүүс нийгэмтэйгээ харьцах явцад гарцаагүй тулгардаг нийгмийн ухамсрын нэг хэлбэр болохынх нь хувьд иргэдийн эзэмшвэл зохих шашны мэдлэг ухааны тухай хөндөж байна. Дэлхийн олон оронд манай улсын адил шашин төрийг тусгаарлан, иргэний сургууль боловсролын газарт шашны номлол заах, зан үйл үйлдэхийг хориглосон хууль байдаг ч бодит байдал дээр өөрсдийн шашны үзэл баримтлалаа ямар нэгэн хэмжээгээр харгалздаг, тодорхой хэмжээгээр дэмжсэн хандлагатай үйл ажиллагаа явуулдаг нь харагддаг.

Америк зэрэг хөгжилтэй оронд шашны боловсролын зорилго нь өөрийн түүх, соёл болоод хүн төрөлхтний соёлыг таньж мэдэх, даяаршиж буй ертөнцийн соёл, шашны олон талт байдлыг ойлгох, асуудлыг зөв шийдвэрлэх, бусдын үзэл бодолд хүлээцтэй, хүндэтгэлтэй хандах чадвар суулгах явдалд чиглэгддэг бөгөөд шашны боловсролыг тодорхой түвшинд олгох нь залуучуудад хүмүүжлийн ач холбогдолтой, тухайлбал, шашны асуудалд нухацтай хандах, үзэл бодол, шашнаар ялгаварлах үзлийг даван туулах, ёс зүйтэй, хүнлэг энэрэнгүй зан чанартай иргэн төлөвшүүлэх, нийгмийн эмх журам, тогтвортой байдлыг тогтооход ихээхэн ач тустай гэж үзэж байна.

Манай орны хувьд, иргэд маань шашны мэдлэг мэдээллийг олж авах нь нээлттэй ч, өнөөгийн түвшинд ул суурьтай мэдлэг боловсрол олж авч чаддаггүй, гол төлөв гэр бүлийнхээ ахмад хүмүүсийн үйлдэл, зан үйлийг дуурайх, утгыг нь үл ойлгох маань мэгзэмээр хязгаарлагддаг нь бидний хийсэн судалгаанаас харагдсан юм²⁴. Тухайлбал, уг судалгаанд хамрагдсан боловсролын салбар хүрээлэлд багтах буддын шашин шүтэгчид “Бурхан багшийн сургаал” номыг уншсан уу? гэсэн асуултанд 31.5 % нь уншсан, 43.8 % нь огт уншаагүй, 24.7 % нь харсан гэсэн байлаа. Шашны мөн чанар,

²⁰Шашин судлал, ред Д.Дагвадорж. УБ.,2001. т 31

²¹История религий. Очерки в двух томах. М.,1988. с124

²²Jonathan Z. Smith. 1998.“Religion, Religions, Religious.” Critical Terms for Religious Studies, edited by Mark C. Taylor. Chicago & London: The University of Chicago Press. p 270.

²³Шашин судлал, ред Д.Дагвадорж. УБ.,2001. т 31

²⁴Энхжаргал.Д “Шашны боловсрол хэрэгтэй юу?” 2008 оны 3-р сар.д хийсэн социологийн судалгаа

түүний эерэг ба сөрөг талыг ялгаж салгахгүй байх нь аминд тулсан эрх ашгийг хохироохгүй хэдий ч ашиг хонжоо хайгчдад завшигдах, боловсрол нимгэн хэсгийг оюуны төөрөгдөл, хоосролд оруулах, янз бүрийн үзэл номлолд автан мунхрах зэргээр өнөөгийн нийгмийн сэтгэлзүйн тогтворгүй байдалд нөлөөлж байгаа нь харагддаг.

Хүний бүхий л үйл хөдлөл, ажил хэргийг эрхзүйн хэм хэмжээний хүрээнд бүрэн тусган зохицуулах боломжгүй учраас тэдгээрийг иргэдийн итгэл үнэмшил, ёс суртахууны тогтсон хэм хэмжээгээр дамжуулан зохицуулж байдаг билээ. Ёсзүйн хэм хэмжээ, шашны зан үйлтэй нягт хослон үйлчлэх нь хэрэгждэггүй хууль дүрмээс ч илүү хүчтэй байх тохиолдол нийгмийн амьдралд бишгүй бий. Энэ тухайд “Шашны сургаал нь ёс суртахууны өндөр зарчим дээр тулгуурлаад зогсохгүй, энэ зарчмыг нийгэмд ёс суртахууны хэм хэмжээ болгон хүмүүсийн үйлдэл ухамсарт суулгаж өгдөг”²⁵ гэсэн судлаачдын дүгнэлтэнд бүрнээ тал өгч болох байна. Энэ үүднээс авч үзвэл, өнөөдөр манайд хичнээн олон хууль батлан гаргалаа ч тэдгээр нь амьдрал дээр тэр бүр хэрэгжихгүй байгаа, хүн нийгмийн харилцааны зохицуулалт зарим талаар алдагдсан явдал нь шашин, сүсэг бишрэлтэй уялдаж, итгэл үнэмшил болсон ёс суртахууны зарчим төлөвшөөгүйтэй холбоотой гэж хэлж болох юм.

Ардчиллын ач буянаар манай орны иргэд “... шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө”²⁶ –г жинхэнэ утгаар нь эдлэх болж, үзэл суртлын хүлээсэнд чөдөрлөгдсөн уламжлалт шүтлэг бишрэл сэргэхийн хамт харийн олон шашны урсгал яах ийхийн зуургүй зэрэгцэн дэлгэрэх болсноос хойш бид багагүй хугацааг өнгөрөөгөөд байна. Ардчиллын тулгуур зарчим, олон ургальч үзлийг дээдэлсэн бид бусад шашныг хаах хорих учиргүй ч, уламжлалт оюун сэтгэлгээгээ алхам алхамаар алдан, глобалчлалын их түрлэгт автах хандлага гарч эхэлсэнд миний бие монголоон гэсэн бусдын адил сэтгэл эмзэглэдэг. Буй болсон энэхүү нөхцөл байдал, түүний дотор залуу үеийнхэн маань харийн шашныг хялбар сонгон дагах болсны шалтгаан нь бидний шүтдэг шашин хуучирч, элэрч баларч байгаад бус, харин бидний шашнаа ойлгох ойлголт ухаарал, мэдлэг боловсрол хоцрогдсонд оршиж байна гэж үзэж байна.

Тиймээс шашны боловсролын асуудлыг эн тэргүүнд монголчуудын уламжлалт шашин болох Буддын шашин дээрээ тулгуурлан хөндөн үзэх нь зүйд нийцнэ. Учир нь Буддын шашин нь олон зууны туршид монголын нийгмийн оюун сэтгэлгээний гүнд нэвтрэн дэлгэрч, хөгжиж

ирэхдээ монгол соёл иргэншилтэй нягт сүлэлдэн холбогдож, түүний өвөрмөц онцлогийг тусган илэрхийлж, шингээн хадгалсан нэгэн үнэт өв болоод зогсоогүй монголчуудын оюуны тусгаар тогтнолын язгуур шинжийг илэрхийлэх бодит хүчин зүйл болсон билээ.

Монгол дахь шашны боловсролын зорилго нь Буддын шашны соёл, мэдлэг ухааны өв уламжлалыг хүүхэд залуус, олон нийтэд эзэмшүүлэх, ёс суртахууны хүмүүжил, хүмүүнлэг үзлийг төлөвшүүлэхэд чиглэгдэх бөгөөд энэ нь дараах тулгуур хуулиудын заалт, үзэл санааг хэрэгжүүлэх үйл хэргийн нэгээхэн хэсэг нь болох юм. Үүнийг Монгол улсын Үндсэн хуулийн: “Монголын ард түмэн бид:...төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж,...эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилгоо болгоно”²⁷ хэмээсэн тунхаглал, Монгол Улсын Боловсролын тухай хуулийн: “Монгол Улсын боловсролын зорилго нь “иргэнийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхтай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэхэд оршино”²⁸ гэсэн заалтуудтай холбон тавьж байна.

Дээрх тулгуур хуулиудын чухам тэрхүү зүйл заалтуудыг ханган биелүүлэх, хэрэгжүүлэх явдалтай шашны боловсролын зорилго, хэрэгцээ шаардлага нягт уялдан гарч ирж буйн дээр оюун сэтгэлгээний ахиц дэвшлийн төлөөх шашин хийгээд иргэний боловсролын чиг зорилгын огтлолцол нь үүнийг нөхцөлдүүлж байна.

Хэдийгээр аль нэг шашныг дөвийлгөн үзэх нь шүтэн бишрэх эрх, эрх чөлөөнд харшлах талтай байж болох хэдий ч Буддын шашны боловсролыг эн тэргүүнд тавьж буй маань нэг талаар, манай ард түмний асар үнэ цэнтэй оюуны сан хөмрөг, уламжлалт өв соёлыг өөртөө шингээн уламжлуулагч нэгэн хүчин болж буйг харгалзан үзсэнд, нөгөө талаар мухар сүсгийг тулгах бус харин хүмүүнлэг үзэл, ёс суртахууны өндөр зарчмуудыг номлодог Буддын сургаалийн өөрийнх нь мөн чанараас урган гарч шүтэлцэж байгаатай холбоотой юм. Тэрчлэн бид Монгол улсын “Төр, сүм хийдийн харилцааны тухай” хуульд: “Төрөөс монголын ард түмний эв нэгдэл, соёл иргэншлийн түүхэн уламжлалаа эрмэлзэхийн үүднээс Монгол Улс дахь буддын шашны зонхилох байр суурийг хүндэтгэн үзнэ. Энэ нь иргэд бусад шашин шүтэхэд саад

²⁵С.Хүрэлсүх, С.Очирсүх “Шашны физик”. Илтгэл, Өгүүлэл, Танилцуулгын эмхтгэл. УБ.,2005. тал 99

²⁶Монгол улсын Үндсэн хууль. УБ.,1992. тал 9

²⁷Монгол улсын Үндсэн хууль. УБ.,1992.тал 3

²⁸Боловсролын тухай хууль.УБ., 2002. 4-р зүйл.

болохгүй”²⁹ хэмээн хуульчлан заасныг эш үндэс болгож, эн тэргүүнд Буддын шашны үзэл сургаалд түшиглэн асуудлыг хөндөн тавьж буй билээ.

Өнөөдөр дэлхий нийтэд Буддын шашин хамгийн шинжлэх ухаанч, хамгийн хүнлэг энэрэнгүй шашин гэдгээрээ нэгэнт танигдаж үнэлэгдээд байна. Тиймээс ч Буддын шашны тэргүүн Дээрхийн гэгээн Далай ламтан Нобелийн шагнал хүртсэн явдлыг уг шашны энэрэн нигүүлсэгч чанар, энх тайванч, эвлэлдэн нийцүүлэгч, гэгээлэг үйлсийг нь дэлхий дахин хүлээн зөвшөөрсний нэгэн илрэл гэж үзэж болно. Эдгээрийг эрхэмлэдэг нь уг шашны мөн чанар билээ

Нигүүлсэхүй, хайр энэрэл, тэвчээр хатуужил, өршөөх чадвар, даруу зан, бусдын тусыг эрхэмлэхүй зэрэг хүмүүнлэг ёсны чанаруудыг төлөвшүүлэх нь Буддын сургаалийн эрхэм зорилго байдаг. Энэ тухайд шашны зүтгэлтнүүд болон эрдэмтэн судлаачид олонтаа дурсан сануулсан нь бий. Далай ламтан: “Шинжлэх ухаан үйл хэргийн боломжтой үр дүнг урьдчилж хэлж тусалж чадахаас биш, бид ёс суртахууны хувьд яах ёстойг хэлж өгөхгүй”³⁰, Роберт Турман: “Будда багшийн айлдсан сургаалд хүний эрхийн зарчмын асуудал бүгд биелэлээ олсон байдаг”³¹ гэх зэргээр тодорхойлж, дэлхий нийт энэхүү сургаалийн давуу талыг нь үнэлэн талархан хүлээн авч байхад бурханы шашны нэг гол төв гэгдэж, олон зууны турш шүтсээр ирсэн бид бүхэн Буддын шашныхаа талаар өргөн дэлгэр мэдлэг, боловсролтой байх нь зүйн ёсны хэрэг бус гэж үү?

Л.Фейрбах “Хүн хүндээ бурхан байх тийм шашин хамгийн зохистой”³² гэж үзсэн байдаг. Тэгвэл Будда бол ямар нэгэн тэнгэр бурхан биш, эгэл жирийн энэ амьдрал дунд гэгээрсэн хүн. Тэрээр хүн бүхэнд төгс төгөлдөрт хүрч гэгээрэх бурхан чанар бий гэдгийг өөрөө батлан харуулж, түүнийг сургаал болгон тальбиж, гэгээрэхийн үндэс нь гагцхүү түүнд хичээж шамдах явдал хэмээн сургасан билээ.

Өөрсдийн үндсэн шүтлэг Буддын шашнаа хадгалж хөгжүүлэхийн ач холбогдлыг олон эрдэмтэн мэргэд дуу нэгтэй хүлээн зөвшөөрч, судалгаа шинжилгээний ажлаа зориулсаар байгаа билээ. Үүнийг “Монголын буддизм гэж нэрлэгдэх боллоо ард олны ахуй амьдрал, ёс заншил, эрдэм ухаанд идээшиж шингэсэн эл шашныг “бурхны шашин олон үеийг дамжин монгол газар дэлгэрэхдээ үндэсний соёлын бүрэлдэхүүн болж, монгол тодотгол бүхий шашин болж чаджээ”³³, “Монгол иргэншлийн хэвшмэл дүр төрхийг илүүтэй илэрхийлж, Монгол хүн монголоороо байж орчин цагийн

бусад хөгжингүй иргэншлийн дэвшилтэт ололтыг хүлээж авах үндэсний суурь дэвсгэрийн язгуур шинжийг өвлөн уламжлуулах нөлөөтэй байна”³⁴, “Хүүхэд залуучуудын шашин шүтлэгийн асуудалд онцгой анхаарал хандуулах ажлуудыг төрөөс зохион байгуулах хэрэгтэй”³⁵, “Өнөө үед шашин шүтлэгээс үүдсэн ухаарал хүмүүжил хийгээд соёлын өв уламжлал, мэдлэг ухааны ололтыг дэмжих, тэдгээрийг судалж, сурталчлах асуудал нэн чухлаар тавигдаж байна”³⁶ гэх зэргээр онцлон дүгнэснээс харж болно.

Шашны боловсрол олгоно гэдэг нь олон түмнийг мунхруулан шашинжуулж, шашны суртал нэвтрүүлэг хийх хэмээсэн хэрэг бус харин тэрхүү шашнаас өнөөдрийн нийгмийн харилцаан дахь сэтгэл зовоосон олон асуудлуудыг шийдвэрлэхэд хувь нэмэр болох, хүнлэг энэрэнгүй үзэл, ёс суртахууны эрхэм чанарууд, эв зөийг эрхэмлэсэн нийтэч үзэл, бусдыг хүлээн зөвшөөрөх, хайрлах, нигүүлсэх, ухаарч гэгээрэх чанар, чадвар зэрэг үнэ цэнэтэй нандин өвийг өнөөшүүлэн өвлүүлэх гэсэн хэрэг юм. Уламжлалт шашин шүтлэгийнхээ талаар үнэн зөв мэдлэгтэй байх нь нийгэм, соёл, ёс зүй, хүмүүнлэгийн ач холбогдолтойг 1994 оноос хойш манай улсад хийгдсэн судалгаануудын дүн, эрдэмтэн судлаачдын үнэлэлт дүгнэлтүүдээс тодорхой харж болно.

Өөрийн шашин, өв соёлоо ойлгож мэдэхийн хирээр хүнлэг чанаруудыг эзэмшиж, бусдын шашин, соёл, уламжлалд хүндэтгэлтэй хандах, аль ч соёл иргэншлийн төлөөлөлтэй нийцэж орших, нийгмийн бүх талын харилцаанд оролцохдоо эерэгээр хандах, эерэг нөлөө үзүүлэх чадвартай болно. Дэвшүүлэн буй асуудлыг хүлээн авах, түүнийг хэрэгжүүлэхийн тулд юуны өмнө бид шашны тухай хуучирсан явцуу ойлголт, сэтгэлгээ, үзэл хандлагаасаа татгалзаж, түүний мөн чанарыг шинээр нээн харахыг эрмэлзэх нь чухал болж байна. Үүний тулд бодож тунгаах, хийж хэрэгжүүлэх зүйлс олон буй.

²⁹ Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль. УБ., 1993. 2-2

³⁰ Далай лам Шинэ мянганы хүмүүн төрөлхтний ёс зүй. УБ., тал 13

³¹ Д.Тунгалаг “Буддизм ба Эрх чөлөө”. Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө. УБ., 2004. тал 128

³² Каламкас Ж “Шашны тухай Л.Фейрбахын баримтлал”- Философи, шашин судлал. Эрдэм шинжилгээний бичиг. МУИС. НШУС. 2007 он. №271(37). х205

³³ Д.Дагвадорж Бурхан шашин, монгол уламжлал”. УБ., 2002

³⁴ Г.Чулуунбаатар “Монгол иргэншил ба шашин шүтлэг: уламжлал, шинэчлэл”. Төр сүм хийдийн харилцаа: орчин үе. УБ., 1998. т42

³⁵ М.Гантуяа “Шашин шүтэх, эс шүтэх эрх, эрх чөлөө алдагдахаас сэргийлэх араг хэлбэрүүд”. Шашин шүтэх, эс шүтэх эрх, эрх чөлөө. УБ., 2004. тал 178

³⁶ Ж.Ухнаа Шашин шүтлэг соёлын өв уламжлал. УБ., 2006. тал 5

Дүгнэлт

Оюун ухаан, мэдлэгт тулгуурласан шинэ зууны Монголын хөгжил дэвшлийн нэг тулгуур нь дэлхийн жишигт нийцсэн, үндэсний онцлог шинж төрхөө агуулсан боловсрол байх учир эл салбарыг хөгжүүлэх чиглэлийг эн тэргүүнд тавьж, тал бүрээс нь анхаарал хандуулж байгаа билээ. Түүнд зүй ёсоор хамаарах нэг чухал тал нь шашны боловсролын асуудал болно. Шашны боловсрол олгоно гэдэг нь шашинжуулах, шашныг тулган хүлээлгэх явдал биш юм.

Орчин цагт шашинтай холбоотой хүмүүсийн танин мэдэхүйн хэрэгцээ өндөр болсон явдал нь шашны боловсролын эрэлт хэрэгцээг хангахад чиглэгдсэн зохих ёсны арга хэмжээ авч явуулах шаардлагыг нөхцөлдүүлж өгч байна. Чухам аль түвшинд, ямар агуулгаар, ямар арга, хэлбэрээр уг боловсролыг олгох вэ гэдэг нь цаашдын судалгааны зорилт болж байна.

Номзүй

1. Боловсролын тухай хууль. УБ., 2002.
2. Гантуяа. М. "Шашин шүтэх, эс шүтэх эрх, эрх чөлөө алдагдахаас сэргийлэх арга хэлбэрүүд". - Шашин шүтэх, эс шүтэх эрх, эрх чөлөө. УБ., 2004.
3. Cornford F.M. From religion to philosophy. Princeton University. 1991
4. Далай лам . Шинэ мянганы хүмүүн төрөлхтний ёс зүй. УБ., 2006
5. Д. Дагвадорж Бурхан шашин, монгол уламжлал" . УБ., 2002
6. Jonathan Z. Smith. "Religion, Religions, Religious." Critical Terms for Religious Studies, edited by Mark C. Taylor. Chicago & London: The University of Chicago Press. 1998
7. История религий. Очерки в двух томах. М., 1988.
8. Каламкас. Ж. "Шашны тухай Л. Фейрбахын баримтлал". - Философи, шашин судлал. Эрдэм шинжилгээний бичиг. МУИС. НШУС. 2007 он. №271(37).
9. Монгол улсын Үндсэн хууль. УБ., 1992.
10. Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль. УБ., 1993.
11. Тунгалаг. Т. "Буддизм ба Эрх чөлөө"- Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө. УБ., 2004. тал 128
12. Ухнаа. Ж. Шашин шүтлэг соёлын өв уламжлал. УБ., 2006.
13. Хүрэлсүх. С., Очирсүх. С. "Шашны физик". Илтгэл, Өгүүлэл, Танилцуулгын эмхтгэл. УБ., 2005.
14. Holmes Rolston, III . Science and Religion: A critical survey. Random House. New York. 1987
15. Чулуунбаатар. Г. "Монгол иргэншил ба шашин шүтлэг: уламжлал, шинэчлэл"- Төр сүм хийдийн харилцаа: орчин үе. УБ., 1998.
16. Шашин судлал. ред Д. Дагвадорж. УБ., 2001.
17. Энхжаргал. Д. "Шашны боловсрол хэрэгтэй юу?" 2008 оны 3-р сард хийсэн социологийн судалгааны материал.